



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайванийн аяган чөлөө 16,  
Баянзүрх дүүргэ, Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 28-23-50,  
Цахим шүүдэн: info@pscr.gov.mn,  
Цахим хуудас: www.pscr.gov.mn

2023.06.02 № А-1/117  
таний -ны № -т

**Чиглэл хүргүүлэх тухай**

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд бурдүүлдэг нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын болон бусад холбогдох бүртгэлийн маягтыг Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар шинэчилж, албан тушаалтны давхар ажил зэрхлэлт болон бэлэг, үйлчилгээний бүртгэлийн маягтыг шинээр баталсан байна.

Уг тушаалаар шинэчлэн болон шинээр батлагдсан холбогдох 10 төрлийн бүртгэлийн маягтыг 2023 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн өөрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ыг үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллана уу. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн холбогдох албан бичиг, маягтуудыг хавсаргав.

Дашрамд дурдахад, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх удирдлагууд авлигын эсрэг хууль тогтоомжид заасны дагуу өөрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ын үйл ажиллагаанд хяналт тавьж, едер тутмын удирдлагаар хангах үүрэгтэй анхаарч, мэдүүлгийн бурдуулэлт, авлигын эсрэг үйл ажиллагааг хариуцсан ажилтныг тогтвортой суурьшилтай ажиллуулах нь зүйтэй байна. Байгууллагын Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ыг тогтвортой суурьшилтай ажиллуулаагүйгээс холбогдох авлигын эсрэг хууль тогтоомжийн хүрээнд бурдүүлэх бүртгэл, тайлан, мэдээ хангалтгүй гарах, өмнөх баримт материал архивд хадгалагдаагүй, хууль тогтоомжийн дагуу хүлээнцээгүй, хариуцсан эзэн холбогдогч тодорхойгүй болох зэрэг хариуцлагагүй байдал үүсэх эрсдэлтэйг анхаарна уу.

ЭБАТ-ыг чөлөөлсөн, томилсон тухай асуудлыг Авлигатай тэмцэх газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт албан ёсоор тухай бурд мэдэгдэх нь зүйтэй. ЭБАТ-ын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх үүднээс шинээр томилогдсон ЭБАТ-ын эрхийг мэдүүлгийн бурдүүлэлтийн цахим систем <https://meduuleg.iaac.mn>-д үүсгүүлэх талаар шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч, тухайн ЭБАТ-ыг томилсон шийдвэр, анкет, баталгааны маягтыг бүрдүүлэн манай байгууллагад албан бичгээр хандаж байхыг зөвлөж байна.

Хавсралт 12 хуудастай

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТӨРИЙН ӨМЧИТ  
БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН  
ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ НАРТ